



ТӨВ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 19 өдөр

Дугаар А/23

Зуунмод

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дүгээр зүйлийн 60.1.1, 60.1.5 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн эх үүсвэрээр хэрэгжих Орон сууцны хорооллын гадна инженерийн шугам сүлжээ (Төв. Зуунмод сум, 1 дүгээр баг) барилгын ажлын худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга:

Б.Ганхуяг Төв аймгийн Засаг даргын Тамгын газрын хууль, эрх
Зүйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Гишүүд:

Я.Пагамаажав Төв аймгийн Засаг даргын Тамгын газрын хөрөнгө
оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн
мэргэжилтэн

Б.Батбаяр Төв аймгийн ГХБХБГ-н газрын удирдлагын
хэлтсийн дарга

Д.Дашдаваа Иргэний төлөөлөл (Аймгийн ИТХ-н Тэргүүлэгчдийн
2019 оны 119 дүгээр тогтоол)

Нарийн бичгийн дарга:

А.Зоригоо Төв аймгийн Орон нутгийн газрын худалдан авах
ажиллагааны албаны дарга

2. Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (Б.Ганхуяг)-д, ашиг сонирхлын зөрчил, авлигаас ангид байх зарчмыг чанд баримтлан, шуурхай зохион байгуулахыг үнэлгээний хороонд үүрэг болгосугай.

3. Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг танилцуулахыг Аймгийн ЗДТГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (С.Магнайбаяр)-д, шилэн дансанд мэдээлэхийг Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагааны албаны дарга (А.Зоригоо)-г даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР

4122010095